

An abstract graphic composed of overlapping, semi-transparent blue shapes, including rectangles and curved lines, creating a sense of depth and movement. The colors range from light sky blue to deep navy blue.

InnoSolution
consulting-solution-support-service

Байгууллагын танилцуулга

Хаяг:
Инносолүшн ХХК
Монгол улс
Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 6-р хороо
Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж
Барилга.МН оффис, 201 тоот
Утас: +976-77447790
Вэб: www.innosol.mn
Имэйл: info@innosol.mn

Агуулга

БИДНИЙ ТУХАЙ	3
БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ	4
СЕРТИФИКАТУУД	5
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО	5
ГОЛЛОХ САЛБАРУУД	6
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ	7
ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ	7
БИД ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?	8
ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ	9
СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ	9
СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ	9
ВИРТУАЛ СЕРВЕР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ	11
ТЕХНОЛОГИ	12
ХАРИЛЦАГЧИД	13
ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД	14

БИДНИЙ ТУХАЙ

ИнноСолюшн ХХК нь Монгол мэдээллийн технологийн салбарт сүүлийн арав гаран жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй чадварлаг инженерүүдээс бүрдсэн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм. Орчин үеийн мэдээллийн технологийн ололт амжилтанд хөл нийлүүлэн алхаж эх орныхоо хөгжил дэвшилд өөрсдийн хувь нэмрийг оруулахаар үйл ажиллагаагаа шинэ түвшинд гаргаж, Монголын оюунлаг залуусын үр ухаанаар шинийг санаачлан бүтээж Монголдоо тэргүүлэн дэлхийд танигдах зорилго, зорилтоо биелүүлэхээр ажиллаж байна.

Бид үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш чамгүй олон ажил үйлчилгээг, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлээд байгаа бөгөөд цаашид ч үйл ажиллагаагаа өргөжүүлэн, хэрэглэгч үйлчлүүлэгчиддээ чанартай, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн технологийн шийдлүүдээр хангаж, ашиглалтын үеийн шаардлагатай үйлчилгээнүүдээр тасралтгүй ханган нийлүүлэн ажиллана.

Алсын хараа

Бид Монгол хүний мэдлэг, чадвараар баялгийг бүтээж улс орны эдийн засгийн эрчимтэй хөгжлийн манлайлагч байх болно.

Эрхэм зорилго

Бид шинэ дэвшилтэт технологийг хөгжүүлэх, шинээр бүтээх, нутагшуулах бүхий л үйл ажиллагааг дэмжин ажиллана.

Үнэт зүйлс

Манай баг хамт олон болон багийн гишүүн бүр манай компанийн үнэт зүйл гэж бид үздэг.

Бидний давуу тал

- Бид байнга шинийг эрэлхийлэгч соёлыг бүрдүүлсэн хамт олон.
- Манай хамт олон салбартаа үнэлэгдсэн мэргэжилтнүүдээс бүрдсэн.
- Бид төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай ажиллаж ирсэн туршлагатай.
- Бид зах зээлд урт хугацаанд тогтвортой ажиллаж байгаа хамт олон.
- Бид олон улсын стандартад нийцсэн аргачлалыг үйл ажиллагаандаа ашигладаг.
- Бид харилцагчидтайгаа хамтдаа бүтээхийг зорьдог.
- Бидний бүтээлээрээ хэрэглэгчдэд үнэ цэнийг хүргэхийг зорьдог.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ

Хүний нөөц бол байгууллагын үйл ажиллагааны хамгийн гол хөдөлгөгч хүч байдаг болохоор Бид нэг зорилго - нэгдмэл зохион байгуулалттай хамтран ажиллаж, бүтээлч - шинийг эрэлхийлэгч шилдэг залуусаар байгууллагын бүх түвшинд багаа бүрдүүлэн ажиллаж байна.



Багийн бүрэлдэхүүн

Инносолюшн ХХК –д дараах мэргэшсэн инженер, техникийн ажилтнууд ажиллаж байна.

- Төслийн зохицуулагч/Ерөнхий менежер
Ахлах программист/Системийн Архитекторч
- Электроникийн инженер
- Мэдээллийн сүлжээний инженер
- Барилгын салбарын инженер
- Үйлдвэрийн автоматжуулалтын инженер
Программист
- Техникийн ажилтан

СЕРТИФИКАТУУД

Инносолюшн ХХК -д Монгол улсын Зөвлөх болон мэргэшсэн инженерүүд ажилладаг ба манай ажилтнууд Мэдээллийн технологийн дараах сертификатуудыг эзэмшдэг.

Мэдээллийн сүлжээ



Аюулгүй байдал



DNS



- DNS workshop
- Internet resource management essentials
- Security Workshop

Мэдээллийн сүлжээний аудит



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

- Инносолюшн ХХК –ийн хамгийн амин чухал хэсэг бол манай ажилтнууд юм. Ажилтнууд болон биет хөрөнгөд гэмтэл бэртэл, хохирол учрах нь компаний нэр хүнд, санхүүгийн амжилтанд сөрөг нөлөөтэй байдаг.
- Инносолюшн ХХК нь тэргүүн түршлага, дэвшилтэт технологид тулгуурлан хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалд манлайлагч байж, осол гэмтлийн тохиолдол гаргахгүй байхыг зорилгоо болгодог.
- Байгууллагын удирдлагын түвшнээс энгийн ажилтан болон гэрээт байгууллагууд хүртэл аюулгүй ажиллагааг хариуцлагатайгаар авч үздэг.
- Инносолюшн дахь аюулгүй ажиллагааны соёлыг бид урт болон богино хугацааны сургалтуудаар дамжуулан түгээдэг.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал бол аливаа төслийн хамгийн чухал хэсгийн нэг гэж бид үздэг.

ГОЛЛОХ САЛБАРУУД

Бид 2006 онд байгуулагдсанаас хойш Мэдээллийн технологийн шийдэл боловсруулах, Үйлдвэрлэлийн автоматжуулалт, Тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт, Захиалгат програм хөгжүүлэлт болон Мэдээллийн технологийн Зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээнүүдийг үзүүлсээр ирсэн бөгөөд энэ салбартаа багагүй туршлага хуримтлуулсан байна.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Танай байгууллагын мэдээллийн технологийн стратегийг бид боловсруулна.

- Энтерпрайз архитектур
- Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах
- Төслийн менежмент
- Цахим засаглал
- Мэдээлэл солилцооны платформ боловсруулах
- Мэдээллийн технологийн аюулгүй байдал
- Мэдээллийн сүлжээ болон Дата төвийн шийдэл
- Програм хангамж хөгжүүлэлт

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ

Бид жижиг дунд бизнесээс эхлээд энтерпрайз түвшний хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн харилцаа холбоо, мэдээллийн сүлжээний шийдлийг боловсруулж, суурилуулалт болон засвар үйлчилгээг мэргэжлийн түвшинд харилцагч нартаа хүргэдэг.

- Сүлжээний шийдэл боловсруулалт
- Мэдээллийн сүлжээний аюулгүй байдал
- Виртуал сервер зохион байгуулалт
- Сүлжээний тоног төхөөрөмж суурилуулалт
- Богино долгионы радио станцийн шийдэл, суурилуулалт
- Дата төвийн угсралт, суурилуулалт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

Бид тасалдалыг багасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх хүчирхэг автоматжуулалтын шийдлийг хүргэнэ.

- Автоматжуулалтын шийдэл боловсруулалт
- Үйлдвэрлэлийн процессийн автоматжуулалт
- Механик болон Электрон төхөөрөмжийн удирдлага болон хяналт
- Барилгын гэрэлтүүлэг, цахилгааны системүүдийн удирдлага болон хяналт
- PLC програм хөгжүүлэлт
- Системийн интеграци, шинэчлэлт
- Автоматжуулалтын бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэлт
- Автоматжуулалтын бүтээгдэхүүн суурилуулалт, засвар үйлчилгээ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Танай байгууллагын мэдээллийн технологийн стратегийг бид боловсруулна.

Бид танай байгууллагын бизнес үйл ажиллагааны зорилгыг хангахтай холбоотой мэдээллийн технологийн стратеги боловсруулах, бизнес процесийг дахин загварчлах, систем хөгжүүлэх болон нэвтрүүлэхтэй холбоотой дараах мэргэжлийн зөвлөх үйлчилгээнүүдийг санал болгож байна.

- Энтерпрайз архитектур
- Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах
- Төслийн менежмент
- Цахим засаглал
- Мэдээлэл солилцооны платформ боловсруулах
- Мэдээллийн технологийн аюулгүй байдал
- Мэдээллийн сүлжээ болон Дата төвийн шийдэл
- Програм хангамж хөгжүүлэлт

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ

ТУРШЛАГАТАЙ ИНЖЕНЕРҮҮД, БЭЛТГЭГДСЭН БАГ: ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ

Төвөгтэй төслүүдэд үр ашигтай шийдэл. Бидний өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшил болгосон процессууд маань харилцагчдын хүлээж буй үр дүнг хугацаанд нь, чанарын өндөр түвшинд хүргэхэд дэмжлэг болдог юм.

Бид байгуулагдсан цагаасаа хойш жижиг дунд бизнесээс энтерпрайз түвшний нэлээд олон төслүүдийг амжилттай гүйцэтгээд байгаа бөгөөд эрсдлийн түвшинг бууруулсан, зардал бага шийдлүүдийг эрхэм харилцагч нартаа нийлүүлээд байна. Бид харилцагчтай хийх анхны уулзалтаас бүтээгдэхүүн нэвтрүүлэх шат хүртэл төслийн менежментийн бүх асуудлуудыг нарийн тодорхойлж хяналт тавин ажилладаг.

Инносолюшн ХХК алхамуудаар Төслийн менежментийн ажлуудыг гүйцэтгэдэг :

- Төслийн эхлэлтийн нарийвчилсан тодорхойлолт
- Судалгаа, загварчлал
- Нийлүүлэгчийн менежмент
- Систем хөгжүүлэлт
- Суурилуулалт, хэрэгжүүлэлт
- Шалгалт, баталгаажуулалт
- Баримт бичгийн боловсруулалт
- Тусгайлсан хэрэглэгчийн сургалт
- Нийлүүлэлтийн дараах тусламж, дэмжлэг
- Засвар үйлчилгээ

БИД ХЭРХЭН АЖИЛЛАДАГ ВЭ?**1.Уулзалт**

Бид нэг загварын үйлчилгээ гаргаад бүгдэд яг ижлийг ашиглахыг тулгадаггүй. Тиймээс нэг хийсэн үйлчилгээний загвараа “Цагт нь дуусгана, төсөвт нь багтаана ” гэсэн улиг болсон үгээр чимсэн аятайхан танилцуулга слайд болгоод 100 гаран удаа нэгэн зэрэг илгээдэггүй. Бид түүний оронд өөрсдийн цагаа тантай хамт суугаад танд тулгарч буй асуудлыг хэлэлцэн, таны юунд хүрэхээр хүсч буйг тодорхойлж бид хоорондоо хэрхэн хамтран ажиллахаа ярилцдаг.

2.Хэлэлцүүлэг,төлөвлөлт

Бид анхны уулзалтын төгсгөлд дараачийн уулзалтаа товлосон бол бид саналаа солилцож эхэлнэ гэсэн үг. Бидний уриа маш энгийн: Санаа гаргах хамгийн амархан ч, гүйцэтгэх нь хавьгүй хэцүү байдаг. Бид зөвхөн хамгийн сүүлийн үеийн шилдэг, технологийн шийдлийг танд санал болгоод зогсохгүй мөнгө санхүү, хэрэглэгчийн санал хүсэлт, системийн суурилуулалт болон түгээлтийн стратеги зэргийг таны бизнесийн үйл ажиллагаатай үялдуулан холбоно. Бид түүнчлэн бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хянаж болохуйц үечлэлүүдэд хуваадаг бөгөөд энэ нь танай дотоод багийн гишүүдийн оролцоо, хүлээж буй үр дүнгийн талаар нэгдмэл ойлголттой байхад чухал үүрэгтэй. Төсөл явагдаж байхад хэн ч гэнэтийн явдалд дуртай байдаггүй.

3.Загварчлал

Бид ямар нэгэн програмчлалын ажлыг эхлэхээс өмнө системийн ноорог зургаас эхлээд ерөнхий бүтэц, гүйцэтгэх үйлдлүүд, харагдах байдал болон ашиглалтын талаарх баримтуудтай таныг алхам алхамаар танилцуулж байх болно. Мөн тухай бүрт нь бидний боловсруулсан загвар болон шийдэл таны бизнесийн зорилготой хэрхэн нийцэж байгаа талаар уулзалтууд хийнэ. Системийг нэвтрүүлсэний дараах бүх харагдац, үйлдлүүд нь, бизнес процессийн өөрчлөлт зэрэг нь бүгд баримтжуулагдсан байх бөгөөд алхам бүрт таны саналыг тусгасан байна.

4.Хэрэглэгчийн ашиглалтын дизайн

Энэ хэсэгт бидний туршлага, таны хүсэл хэрхэн үр дүнтэй нийлж байгааг үзүүлэх юм. Бид системийн ашиглалт сайжруулах аргачлал болон технологийг хослуулан хэрэглэгчийн хэрэглээний хандлагыг судлах замаар хялбар систем бий болсон эсэх байнга шалгадаг.эцсийн бүлэгт програм хангамж юу хийдэг нь гол биш, түүнийг ашиглан хэрэглэгч юу хийж чаддаг нь чухал юм.

5.Систем хөгжүүлэлт

Бид зөвхөн системийн загвар дизайныг гаргаад зогсохгүй бизнесийн тань хүнд ачааг үүрэх бодит ажиллах системийг ч хийдэг. Та моторгүй машин худалдаж авдаг уу? Манай хөгжүүлэгчид төслийн анхан шатнаас эхлээд судалгаа, загвар боловсруулалтын багтайгаа хамтран ажиллаж эхэлдэг бөгөөд харилцагчидтайгаа нэг баг болж харилцан итгэлцлийг үүсгэдэг.

6.Гүйцэтгэл

Гүйцэтгэл болон өргөтгөлийн төлөвлөгөө маш эртнээс эхэлдэг. Та моторгүй машин худалдаж авахгүй шиг та яагаад Феррари арьстай Волксваген мотортой машин авахаар зүтгээд байна? Удаан ачаалагддаг хуудаснууд хэрэглэгчийн хүслийг мохоодог болохоор та бизнесийн амжилтаа тэмдэглэх үү эсвэл серверийн өндөр зардалдаа дарлуулах үү гэдэг ялгаатай зам дээр очно. Гүйцэтгэлийг дараа нь гэж бид орхидоггүй.

7. Интеграци нэгтгэл

Таны шинэ систем бусад хуучин системүүдтэй чинь хамтрагчид шиг л хоршин ажилладаг байхыг хүсэж байгаа биздээ. Бид системүүдийн хооронд болон Facebook, Twitter, Youtube, Google+ зэрэг гуравдагч системүүдтэй нэгтгэл хийх дадлага туршлагатай.

ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ

Бид жижиг дунд бизнесээс эхлээд энтерпрайз түвшний хэрэглэгчдийн шаардлагад нийцсэн харилцаа холбоо, мэдээллийн сүлжээний шийдлийг боловсруулж, суурилуулалт болон засвар үйлчилгээг мэргэжлийн түвшинд харилцагч нартаа хүргэдэг.

- Сүлжээний шийдэл боловсруулалт
- Мэдээллийн сүлжээний аюулгүй байдал
- Виртуал сервер зохион байгуулалт
- Сүлжээний тоног төхөөрөмж суурилуулалт
- Богино долгионы радио станцийн шийдэл, суурилуулалт
- Дата төвийн угсралт, суурилуулалт

СҮЛЖЭЭНИЙ ШИЙДЭЛ

СҮЛЖЭЭНИЙ ИЖ БҮРЭН ШИЙДЭЛ: ЗАГВАРЧЛАЛ, СУУРИЛУУЛАЛТ БОЛОН ӨРГӨТГӨЛ

LAN, WAN, MPLS гэх мэт таны бизнест шаардлагатай дэд бүтэцтэй болоход Инносолюшн энгийн хялбар шийдлүүдээ санал болгож байна. Шинэ сүлжээ үүсгэх, хуучин дэд бүтцийн өргөтгөл эсвэл шинэ аппликэйшн нэвтрүүлэх ажлуудад бид үйлчилгээгээ үзүүлж байна. Сүлжээний загварчлал болон суурилуулалтын ажлаа Инносолюшнд даатгаснаар танай бизнес илүү үр ашигтайгаар үйл ажиллагаагаа явуулах болно.

Инносолюшн дараах сүлжээний шийдэл боловсруулах үйлчилгээг үзүүлж байна:

- Local Area Network
Бид Дотоод(LAN) сүлжээнд шинжилгээ хийх , зөвлөгөө өгөх, шийдэл боловсруулах, суурилуулах, оношлогоо, менежмент, удирдлага болон сургалтаар хангана.
- Wide Area Network
Бид WAN сүлжээнд шинжилгээ хийх , зөвлөгөө өгөх, шийдэл боловсруулах, суурилуулах, холболтын тоног төхөөрөмж нийлүүлэх, voice over IP (VOIP)/ MPLS .
- Төлөвлөлт, зохион байгуулалт бүхий кабелийн холболт, суурилуулалт
Кабель суурилуулах орчны шинжилгээ, кабелийн менежментийн загвар, мэдээлэл болон дуу дамжуулах кабелийн суурилуулалт, үйлдвэрлэгчийн онцлогоос хамаарсан кабелийн холболт, тохиргоонууд

СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

ЦАХИМ ЕРТӨНЦӨД ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ АЮУЛ: СҮЛЖЭЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ҮР ДҮНТЭЙ ХАНГАХ

Аюулгүй байдлыг цар хүрээ нь байгууллагын болон үйлчлүүлэгчдийн мэдээллийн аюулгүй байдлыг хэр хангаж байгаагаар хэмжигдэнэ. Сүлжээ болон мэдээллийн аюулгүй байдлын талаар мэргэшсэн Инносолюшн ХХК нь стратегийн зөвлөгөө, сургалт болон нэвтрүүлэлтийн үйлчилгээг үзүүлдэг. Манай түршлагатай аюулгүй байдлаар мэргэшсэн инженерүүд гарч болохуйц сүлжээний эмзэг байдлуудыг илрүүлэн, урт хугацааны аюулгүй байдлын стратегийн төлөвлөгөөг боловсруулахад тусална.

Бид Сүлжээний аюулгүй байдалтай холбоотой дараах үйлчилгээг үзүүлдэг:

- Нэвтрэх хяналт/ Аудит
- Анти-Вирус, spyware хамгаалалт
- Имэйл/Вэб агуулгын шүүлтүүр
- Шифрлэлт, нууцлалтсистемүүд
- Галт ханы менежмент
- Virtual Private Networks (VPNs)

ВИРТУАЛ СЕРВЕР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ӨСӨЛТӨНД БЭЛЭН БАЙ: СЕРВЕРИЙН ВИРТУАЛЧЛАЛ

Хаягдлаа бууруул, бэлэн байдлаа хангаж зардлаа удирд. Инносолюшн серверийн виртуалчлал болон дундын мэдээллийн сангийн шийдлийг санал болгож танай байгууллагын ирээдүйн өсөлтийн үе дэх бэлэн байдлыг хангана. Серверийн тоног төхөөрөмжийн тэлэлт нь удирдахад төвөгтэй байх, хязгаарлагдмал бэлэн байдал үүсэх болон зардлын өсөлт рүү хөтөлдөг ба Серверийн виртуалчлал нь нь эдгээрээс сэргийлж чадна.

- Тоног төхөөрөмжийн шаардлагуудыг бууруулж үйл ажиллагааны зардлыг 50% хүртэл бууруулна.
- Дата төвийн цахилгаан зарцуулалтыг 80 хүртэл хувиар бууруулна.
- Серверүүдийн ашиглалтыг 25% хүртэл нэмэгдүүлнэ.
- Бүх хэрэглэгчдэд өндөр түвшний бэлэн байдлыг байнга үзүүлнэ.
- Засвар үйлчилгээг хэрэглэгч болон үйлчилгээнд саад болохгүйгээр хэдийд ч үзүүлж болно.
- Яаралтай нөхцөл байдал үүссэн үед системийг нөхөн сэргээх олон алхамуудыг алгасан хялбар аргаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Бизнесийн үйл ажиллагааны хэмжээнээс үл хамааран бизнесийн шаардлагатай мэдээллүүдэд шууд хандах боломж бүрдэнэ.
- Алдаа гарах боломжийг бууруулж, сул нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлнэ.
- Эцсийн хэрэглэгчийн гүйцэтгэлийг оновчтой хангах хялбар өргөтгөх боломж

Та Виртуалчлалд бэлэн боллоо. Бид хялбарханаар шийдье.

Манай сертификаттай инженерүүд танай одоогийн мэдээллийн технологийн орчин болон бизнесийн зорилго дээр шинжилгээ хийж тохирсон шийдлээр ханган танай байгууллагын серверүүдийг виртуалчлах болно.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АВТОМАТЖУУЛАЛТ

Бид тасалдалыг багасгах, бүтээмжийг нэмэгдүүлэх хүчирхэг автоматжуулалтын шийдлийг хүргэнэ.

**Rockwell
Automation**

 **Allen-Bradley** • *Rockwell Software*



Бид дэлхийд тэргүүлэгч үйлдвэрлэлийн автоматжуулалтын шийдэл боловсруулагч, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Америкийн Rockwell Automation компанитай хамтран ажилладаг бөгөөд дараах үйлчилгээнүүдийг харилцагч нартаа хүргэж байна.

- Автоматжуулалтын шийдэл боловсруулалт
- Үйлдвэрлэлийн процессийн автоматжуулалт
- Механик болон Электрон төхөөрөмжийн удирдлага болон хяналт
- Барилгын гэрэлтүүлэг, цахилгааны системүүдийн удирдлага болон хяналт
- PLC програм хөгжүүлэлт
- Системийн интеграци, шинэчлэлт
- Автоматжуулалтын бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэлт
- Автоматжуулалтын бүтээгдэхүүн суурилуулалт, засвар үйлчилгээ

Процессийн автоматжуулалт

- Шинэ процесс, үйлдвэрийн дамжлагыг автоматжуулах
- Инженерчлэл болон хэрэгжүүлэлт
- Автоматжуулалтын тоног төхөөрөмж нийлүүлэлт

Хуучин системүүдийг шилжүүлэх

- Хуучин системүүдийг орчин үеийн платформуудтай интеграци хийх, шилжүүлэх
- Системийн оптимизаци

Автоматжуулалтын бүтээгдэхүүн үйлчилгээ

- System re-control – modifications
- VSD, моторын удирдлагын панелууд
- Удирдлагын системийн панел угсралт
- Эрчим хүчний хяналт
- Цахилгааны утас, кабелийн суурилуулалт

PLC програм хөгжүүлэлт

- Rockwell Automation - Загварчлал:
 - Studio5000
 - FactoryTalk AssetCentre
 - RSLogix 5000

Байгууллагын танилцуулга

- Communications
- Rockwell Automation - Үйлдвэрлэлийн ухаалаг тайлан, төлөвлөгөө:
 - FactoryTalk VantagePoint
 - FactoryTalk Historian
 - FactoryTalk EnergyMetrix
- Бусад: Unity Pro, CX-One

ТЕХНОЛОГИ

Өгөгдлийн сангууд



Серверийн платформууд



Виртуалчлалын технологиуд



Үүлэн тооцоолол



Сүлжээний технологиуд

Сүлжээний тоног төхөөрөмжийн салбарын шилдгүүд болох Cisco, Linksys, D-Link компаниудын бүтээгдэхүүн болон Линукс-т суурилсан сүлжээний програм хангамжуудыг ашиглан байгууллагуудад сүлжээний зохион байгуулалтын шийдэл болон суурилуулалтын үйлчилгээг хэрэглэгч нартаа хангаж байна.

ХАРИЛЦАГЧИД

МТШХХГазар, Үндэсний Дата төв, Мобиком Корпораци, Юнител ХХК, Моннис Групп, Гранд Повэр ХХК, Синус Дочи ХХК, Бодь Электроникс ХХК, Монголын Алт ХХК, ХансКоммуникэйшн ХХК, Канто Констракшн, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, ВНР Билитон Монголиа, Тетис Майнинг Монголиа, НИК ХХК, Шивээ овоо ХК, Бест рөүд ХХК, Монголын Хөрөнгийн Бирж, ГЕГазар, УБЕГ, Татварын Ерөнхий Газар, Засаг даргын тамгын газрууд: Дорнод, Дундговь, Дорноговь, Орхон аймгийн ЗДТГ



ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

Бидний амжилтын үндэс зогсолтгүй үргэлжлэн хийгддэг шинэ санал, санаачлага байдаг. Бид хэрэглэгчдээ анхааралтай сонсож тэдэнд шаардлагатай ажил үйлчилгээний шийдлүүдийг боловсруулж, бүтээгдэхүүнээ цаг тухайд нь чанарын стандартын өндөр түвшинд нийлүүлэн ажиллаж байна. Үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш чамгүй олон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж захиалагч нартаа хүлээлгэн өгөөд байна.

Сүүлийн 4 жилд хэрэгжүүлсэн төслүүд, ажил үйлчилгээний жагсаалт

№	Төслийн нэр	Захиалагч	Ажлын төрөл, он
1	Төрийн энтерпрейз архитектур болорсвуулах зөвлөх үйлчилгээ	МТШХХГ	2013 он. ЕА зөвлөх үйлчилгээ
2	Төрийн нэгдсэн өгөгдлийн сан боловсруулах зөвлөх үйлчилгээ	МТШХХГ	2014 он. Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ
3	Цахим нотариатын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээ	Монголын Нотариатчидын танхим	2015 он. Мэдээллийн технологийн зөвлөх үйлчилгээ
4	Дотоод сүлжээ, Дата төвийн шийдэл боловсруулалт, суурилуулалт	Монгол улсын боловсролын их сургууль	2015 он. Зөвлөх үйлчилгээ, мэдээллийн сүлжээ
5	Дотоод сүлжээ, Дата төвийн шийдэл боловсруулах зөвлөх үйлчилгээ	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	2015 он. Зөвлөх үйлчилгээ, мэдээллийн сүлжээ
6	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээг эрхэлдэг түсгай зөвшөөрөл эзэмшигчдийн онлайн бүртгэлийн програм хангамж боловсруулах төсөл	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл	2015 он. Зөвлөх үйлчилгээ, програм хангамж
7	Хөдөө аж ахуйн биржийн Дата төвийн шийдэл боловсруулах төсөл	Монголын Хөдөө аж ахуйн бирж	2015 он. Зөвлөх үйлчилгээ, мэдээллийн сүлжээ
8	Цахим төлбөрийн системийн технологийн шийдэл, ажлын даалгавар боловсруулах зөвлөх үйлчилгээ	EzPay ХХК	2016 он. Зөвлөх үйлчилгээ болон програм хангамж
9	Фитнесийн бүртгэлийн програм хангамж боловсруулах, Цахим цоож суурилуулах	Моннис пропертис ХХК	2016 он. Програм хангамж болон тоног төхөөрөмжийн суурилуулалт
10	Танилцуулга веб сайт хөгжүүлэлт	ТАТА ТРЕЙД ХХК	2016 он. Програм хангамж
11	GPS дээр суурилсан тээврийн хэрэгсэлийн хяналтын систем	Петросайна дачин тамсаг ХХК	2016 он. Програм хангамж болон тоног төхөөрөмжийн суурилуулалт
12	Сүлжээний шийдэл болон зөвлөх үйлчилгээ	Глобал Велдинг Монгол ХХК	2017 он. Зөвлөх үйлчилгээ
13	МҮОНРТ-ын төв байрны хяналтын систем	МҮОНРТ	2017 он. Програм хангамж болон тоног төхөөрөмжийн

			суурилуулалт
14	Шинээр байгуулагдсан 15 хороодын шилэн кабель, дотоод сүлжээ, серверийн өргөтгөл, тоног төхөөрөмж нийлүүлэлтийн ажил	БЗД-ийн ЗДТГ	2023 он. Компьютерийн сүлжээний тоног төхөөрөмж
15	Хогийн цэгийг камержуулах, гэрэлтүүлэг тавих	Төв аймгийн Эрдэнэсант сумын ЗДТГ	2023 он. Хяналтын камер, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж
16	Камержуулалт (4, 5, 6, 7, 8, 9, 10, 12, 13, 14, 16, 21 дүгээр хороо)	ХУД-н ЗДТГ	2023 он. Хяналтын камерийн систем
17	Цагдаагийн камержуулалтын тоног төхөөрөмж	Архангай аймгийн ЗДТГ	2023 он. Хяналтын камерийн систем
18	“Дэд станцуудад аккумуляторын байгууламж шинээр суурилуулах ажлын материал”	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ	2023 он. Аккумуляторын байгууламж нийлүүлсэн.
19	ӨРГӨӨ-2 ХОТХОНЫ ГАДНА ДОТОР ХОЛБОО, ХЯНАЛТЫН КАМЕРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ	Эм Би Эм Ти Эм Констракшн ХХК	2023 он. Барилгын гадна болон дотор холбоо, хяналтын камер, зарлан мэдээлэх сүлжээ
20	Олон улсын төлбөр тооцооны системийн судалгаа болон хөгжүүлэлт	Ти Энд Ти Про ХХК	2023 он. Зөвлөх үйлчилгээ
21	Бор-Өндөр дэд станцад IP хяналтын камер суурилуулах	Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ	2023 он. Хяналтын камерийн систем
21	Залуус-1,2 хорооллын холбоо дохиоллын ажил /Дархан-Уул аймаг, Дархан сум/	Барилга хот байгуулалтын яам	2023 он. Гадна холбооны ажил гүйцэтгэсэн.
22	Хурлын заалны иж бүрдэл төхөөрөмж болон сүлжээний тоног төхөөрөмж, камерыг нийлүүлэх	Юби роботикс ХХК	2023 он. Тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ.
23	Чойбалсан хотын төв авто замд гэрлэн дохио суурилуулах ажилд шаардлагатай бараа материал (Хэрлэн сум)	Дорнот аймгийн ЗДТГ	2023 он. Авто замын гэрлэн дохионы бараа материал нийлүүлэх
24	Хуучин гэрэлтүүлэгүүдийн засвар үйлчилгээ	Төв аймгийн Эрдэнэсант сумын ЗДТГ	2023 он. Гудамж талбайн гэрэлтүүлгийн засварын ажил
25	Төрийн үйлчилгээний төлбөрийн системд middleware нэвтрүүлэх архитектур боловсруулалт болон гүйцэтгэл	Гэрэгэ ХХК	2023 он. Төрийн үйлчилгээний төлбөрийн системийн зөвлөх үйлчилгээ
25	“Зуунмод сумын нутаг дэвсгэрт камержуулалт /6-н багт/”	Төв аймгийн зуунмод сумын ЗДТГ	2024 он. Хяналтын камерийн систем
26	“Камерын хяналтын тоног төхөөрөмж, угсралт суурьлуулалт”	Таван толгой ХК болон Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЗДТГ	2024 он. Хяналтын камерийн систем